

**Статистикийн хэлтсийн 2 дугаар сарын 23-наас 3 дугаар сарын 01-ний
өдрийг хүртлэх 7 хоногт хийсэн
ажлын товч мэдээ**

2018.03.01

Өлгий

1. ҮСХ-ноос Дэлхийн Тогтвортой хөгжлийн зорилго /ТХЗ/-ын хэрэгжилтийг дүгнэх үзүүлэлтүүдийг тооцон гаргах ажлыг эхлүүлж, 1212.mn вэб сайтад тусгай булан нээж, мэдээллийг тархааж байна. ТХЗ-ын үзүүлэлтүүдээс Аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийн судалгааг хавсаргасан хүснэгтийн дагуу гаргаж, заасан хугацаанд хүргүүлж ажиллав.
2. Хамтарсан хяналт шинжилгээ үнэлгээ хийхтэй холбогдуулан сум, багийн түвшинд гарах үзүүлэлтүүдийг бэлтгэсэн.
3. Төрийн албаны зөвлөлөөс ирсэн орон тооны гишүүн Т.Цэдэндамба, ахлах референт Т.Сосорбарам нарын төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын талаар явуулсан сургалтад оролцов.
4. Төсвийн гүйцэтгэлийн зарлагын 2 дугаар сарын мэдээг хугацаанд хүргүүлэв.
5. Прокурорын газраас зохион байгуулсан “Нийтэд тустай ажил хийлгэх ялын хэрэгжилт” сэдэвт хэлэлцүүлэгт оролцож, санаа бодлоо солилцов.
6. Өрхөд суурилсан нийгэм эдийн засгийн болон ажиллах хүчний судалгааны судлаач нарын хариуцсан мэдээ, тайлангийн графикийг батлав.
7. Үндэсний статистикийн хорооноос ирүүлсэн тээврийн салбарын мэдээний улирлын хүрээний тодруулга хийв.
6. Аж Ахуйн нэгж, байгууллагын ААНБ-1 ба ААНБ-2 жилийн эцсийн мэдээ, тайлан цуглуулан авч шалгалт хийж, 42.3 хувийг программд оруулав.

Статистикийн хэлтэс